



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/726

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “МӨНГӨН ЦЭЛМЭГ НОЁД ГРУПП” ХХК-ий хийж гүйцэтгэсэн Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Буянт сум/ 6 дугаар багц ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын авто замын хяналтын улсын байцагч

Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга

И.Гантогтох - Ховд аймаг дахь цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах байцагч, ахлах зохицуулагч цагдаагийн хошууч

С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Ч.Нэргүй - Буянт сумын Засаг дарга

Д.Хүрэлбаатар - “МӨНГӨН ЦЭЛМЭГ НОЁД ГРУПП” ХХК-ний захирал

Нарийн бичгийн
дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг Даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. "МӨНГӨН ЦЭЛМЭГ НОЁД ГРУПП" ХХК-ий хийж гүйцэтгэж буй Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Буянт сум/ 6 дугаар багц ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажлын ажлын хэсгийн холбогдон гаргах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН